



Харилцагч Та өөрийн мэдээллийн аюулгүй байдлаа хангаж, болзошгүй эрсдэлээс хамгаалаарай

Харилцагчдын хувийн мэдээллийг олж аван, улмаар дансан дахь мөнгийг нь луйвардах тохиолдлууд гарч байгаа талаар хууль хяналтын байгууллагаас мэдээлж байгаа тул **ХАРИЛЦАГЧ ТА** өөрийн мэдээллийн аюулгүй байдалдаа онцгой анхаарч, доорх **ЗӨВЛӨМЖТЭЙ** танилцан учирч болзошгүй эрсдэлээс сэргийлнэ үү.



Та хувийн и-мэйл хаяг болон цахим банкны үйлчилгээндээ нэвтрэхдээ үнэгүй Wi-Fi сүлжээ болон нийтийн компьютер бүү ашиглаарай.



Банк Таны цахим банкны **нууц үгийг** асуусан и-мэйл **хэзээ ч явуулахгүй** тул ийм төрлийн мэдээлэлд хууртахгүй байж, банканд мэдэгдэж шалгуулаарай.



Та өөрийн компьютероо вирусны эсрэг программаар хамгаалж, шинэчлэлийг тухай бүрт хийж байгаарай.



Цахим банкны үйлчилгээ, хувийн болон албаны и-мэйл хаягны нууц үгийг том жижиг үсэг, тэмдэгт оролцуулан хийж байх, нууц үгээ тогтмол шинэчлэн, өөр бусад цахим хаягны нууц үгтэй давхардуулахгүй байхыг анхаараарай.



Та өөрийн дансны хуулгаа тогтмол хянаж, сэжигтэй гүйлгээ байвал банктай холбогдоорой.



Таны байнгын харилцаатай түншээс төлбөр шилжүүлдэг **дансны дугаар өөрчлөгдсөн**, өөр данс руу төлбөрийг шилжүүлэхийг хүссэн и-мэйл ирвэл үнэн эсэхийг баталгаатай эх сурвалжаас заавал лавлаж **баталгаажуулаарай**.



Адил төстэй бичигдэх, харагдах вэб сайт, и-мэйл хаягийг хуурамчаар үүсгэн залилах үйлдэл түгээмэл байдаг тул сайтар шалгаж, баталгаажуулж байгаарай. Жишээ нь: support@yahoo.com - support@yahoo.com



Та их хэмжээний мөнгө сугалаанд хожсон, өв залгамжилсан, эсвэл хэн нэгэнд туслах шаардлагатай байгаа тухай, мөн гадаад төслийн зээлийн санал зэрэг мэдээлэл и-мэйл, гар утсанд тань мессежээр ирсэн бол цахим луйврын гэмт хэрэг байж болохыг анхаараарай.



Мөн та байгууллагынхаа цахим шууданг шаардлагагүй вэб сайт, бусад онлайн үйлчилгээнд бүртгүүлэхгүй байхад анхаарч, байгууллагынхаа цахим шууданг ашиглахдаа шифрлэлтийн программ PGP (Pretty good Privacy) болонбусад нууцлалын технологийг ашиглаж хэвшээрэй.



Олон нийтийн интернэт сүлжээнд цахим банкны үйлчилгээг ашигласан бол тухай бүр "Log out" товчийг дарж, цахим банкны үйлчилгээнээсээ гарч хэвшээрэй.